



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Засгийн газрын 10 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 170,207,734.00 (нэг зуун далан сая хоёр зуун долоон мянга долоон зуун гучин дөрвөн) төгрөгийн балансын үнэ, 11,033,706.11 (арван нэгэн сая гучин гурван мянга долоон зуун зургаан төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Төрийн банк" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Ганбат, гүйцэтгэх захирал Ө.Гантөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Архивын барилга буулгаж, чөлөөлсөн газрыг байгууллагын архивын албан конторын зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;

2.3. Шинээр авсан 406 м.кв талбай бүхий газрыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр үнэлж балансад тусгах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000728

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ний
өдрийн 386 дугаар тогтоолын хавсралт



**"Төрийн банк" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах
хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Архивын барилга	2002	ш	1	170,207,734.00	11,033,706.11	159,174,027.89
					170,207,734.00	11,033,706.11	159,174,027.89
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				170,207,734.00 (нэг зуун далан сая хоёр зуун долоон мянга долоон зуун гучин дөрвөн)	11,033,706.11 (арван нэгэн сая гучин гурван мянга долоон зуун зургаан төгрөг арван нэгэн мөнгө)	159,174,027.89 (нэг зуун тавин есөн сая нэг зуун далан дөрвөн мянга хорин долоон төгрөг наян есөн мөнгө)